

ПОСТМОДЕРН ТӨЛӨВ: МЭДЛЭГИЙН ТУХАЙ ИЛТГЭЛ ЗОХИОЛЫН ХЭСГЭЭС¹

Жан-Франсуа Лиотар

3. Арга: Хэлний тоглоом

Тодорхойлсон хүрээндээ асуудлыг задлан шинжлэхийн тулд хэлний баримтуудыг, ялангуяа эдгээр баримтын прагматик талыг¹ онцлон гаргах арга ажиллагааг илүүд үзнэ гэдгээ мэдэгдье. Үүнээс мөрдөн гарах зүйлийг тодруулахын тулд *прагматик* гэдэг нэр томъёог юу гэж ойлгож байгаагаа товч боловч өгүүлэх нь зүйтэй.

Яриа, ярилцлагын дунд дурдагдах “Их сургууль өвчилжээ” гэх мэтийн денотатив хэллэг² илгээгчээ (түүнийг хэлсэн хүнийг), хүлээн авагчаа (түүнийг хүлээн авч байгаа хүнийг), референтээ (түүнд яригдаж буй зүйлийг) онцгой байдлаар байршуулдаг. Энэ хэллэгээр илгээгч нь “танин мэдэгчийн” байранд (тэрээр их сургуулийн тухай ямар нэг юм мэдэж байна), хүлээн авагч үүнийг хүлээн зөвшөөрөх эсвэл татгалзах байранд, өөрийн ээлжинд референт нь денотатив байдлаар өөртэй нь таарч байх хэллэгт зөв илэрхийлэгдэж, адилтгагдаж байхыг шаарддаг зүйлийн байранд дэвшигдэнэ.

Хэрвээ хичээлийн шинэ жилийн нээлтийн ёслолын ажиллагааны үеэр ректор эсвэл деканы хэлсэн “Их сургууль нээгдлээ” гэх маягийн хэллэгийг аваад үзвэл өмнө дурдсан онцолбор шинжүүд хамааралгүй болсоныг харж болно. Хэллэгийн утгыг ойлгох ёстой нь мэдээж, гэхдээ энэ бол харилцааны ерөнхий нөхцөл бөгөөд хэллэгийн янз бүрийн төрөл, тэдний онцгой нөлөөг ялгахад тус болохгүй. Перформатив³ гэгдэх хоёрдахь хэллэгийн онцлог нь референтдээ үзүүлэх түүний нөлөө хэллэгтэйгээ давхацдагт оршино, учир нь дээр дурдсан нөхцөлд нээгдсэнийг нь зарлаж байгаа учраас л их сургууль нээгдэж буй юм. Ингэхлээр энэ нь хэллэгээр бий болох шинэ контекстэнд шууд байрших хүлээн авагчийн талаас шүүн хэлэлцэх эсвэл шалган үзэх зүйл биш. Илгээгчийн тухайд гэвэл тэр нь иймэрхүү хэллэгийг хэлэх эрх мэдлээр хангагдсан байх ёстой. Үнэндээ үүнийг эсрэгээр ч илэрхийлж болно, жишээлбэл, иймэрхүү төрлийн хэллэгийг хэлэх эрх мэдлээр хангагдсан хүн буюу ректор эсвэл декан нь түрүүн хэлсэнчлэн референт буюу их сургуульдаа ч, хүлээн авагч буюу их сургуулийн ажилчиддаа ч шууд нөлөөлж чадах учраас л ректор эсвэл декан болж байгаа юм.

Прескриптив байх, “Их сургуульд хөрөнгө гаргаж өг” гэх маягийн хэллэгүүд өөр тохиолдлыг төлөөлнө. Тэд тушаал, заавар, сайшаал, гуйлт, хүсэлт, өргөдөл гэх мэт хэлбэртэй байж болно. Илгээгч нь энд үгийнхээ өргөн утгаар (бурханд хандан өршөөн нигүүлсэхийг гуйгч нүгэлтний эрх мэдлийг ч багтаасан) эрх мэдлийн байр сууринд тавигддаг, өөрөөр хэлбэл тэрээр хүлээн авагчаас хамаарах үйлдэл хийхийг хүлээж байдаг. Прескриптив прагматик нь хүлээн авагч, референт хоёрын байранд дагалдагч өөрчлөлтүүд үүсгэнэ⁴.

Асуулт, амлалт, уран сайхны бичлэг, өгүүлэмж гэх мэтийн нөлөөлөх байдал ч ондоо юм. Үүнийг би товчиллоо. Витгенштейн хэлийг шинээр судлаж эхлэхдээ анхаарлаа янз бүрийн өгүүлэмжийн нөлөөнд хандуулж, олж тогтоосон хэллэгийн янз бүрийн төрлөө (би заримыг нь л тоочлоо) *хэлний тоглоом* гэж нэрлэжээ⁵. Хэлний тоглоом гэдэг нэр томъёогоор тэрээр шатрын тоглоомыг дүрс бүрийн шинж чанарыг, тодруулбал тэдний нүүх замыг тогтоодог цогц дүрэм тодорхойлдог шиг хэллэгийн төрөл бүрийн ангийг тэдний шинж чанарыг тодорхойлж, хэрэглээг нь тогтоодог дүрмээр тодорхойлж болохыг илэрхийлсэн юм.

¹ Орчуулсан Ц.Нямсүрэн, Б.Дагзмаа \Ph.D\

Хэлний тоглоомын талаар дараах гурван зүйлийг сануулах хэрэгтэй. Нэгд, дүрэм нь өөртөө хуульчлалаа агуулдаггүй ч тоглогчдын хооронд илэрхий эсвэл илэрхий бус зөвшилцсөн зүйл байдаг (гэхдээ энэ нь тоглогчид дүрмээ санаанаасаа зохиодог гэсэн үг биш). Хоёрд, хэрэв дүрэм байхгүй бол тоглоом ч байхгүй⁶, дүрмийн багахан өөрчлөлт ч тоглоомын мөн чанарыг өөрчилдөг, харин дүрмийг биелүүлээгүй “нүүдэл” буюу хэллэг тэр дүрмээр тодорхойлогдогч тоглоомд хамаагүй. Гуравт, зөвхөн юу хэлэгдсэнээр л ойлгогдоно; хэллэг бүр тоглоом дахь “нүүдэл” шигээр төсөөлөгдөх ёстой.

Сүүлийн энэхүү сануулга бидний аргыг бүхэлд нь тодорхойлж буй эхний зарчимд хөтөлж аваачна: ярина гэдэг нь тоглоомын утгаар бол тэмцэлдэнэ гэсэн үг бөгөөд ярих үйл⁷ нь бүхнийг хамарсан тулааны талбарт хамаарна⁸. Энэ нь ялахын тулд л тоглодог гэсэн үг огт биш. Бодож олсоноосоо хүртэх таашаалын төлөө нүүдлийг хийж болно. Алдартай үг, уран зохиолоор бий болсон хэлний хэцүү илэрхийлэлд өөр юу байдаг вэ? *Ярианы* түвшин дэх хэлний хувьслын цаана өрнөх үйл явц болох хэлц, үг, утгын хувиралыг байнга бодож олох нь маш тааламжтай байдаг. Гэхдээ ийм таашаал ч наанадаж хүчтэй нэг өрсөлдөгч буюу хүлээн зөвшөөрөгдсөн хэл эсвэл коннотацийг⁹ дийлсэн амжилтын мэдрэмжээс хамаардаг нь эргэлзээгүй.

Хэлний тэмцэлдээний тухай энэ санаа үүнд нэмэлт болдог, бидний анализыг тодорхойлж байгаа, нийгмийн ажиглагдам холбоо нь хэлний “нүүдлүүдээс” тогтдог гэсэн хоёрдахь зарчмыг далдлах учиргүй. Энэ үндэслэлийн тайлбар биднийг гол сэдэвт маань оруулна.

(Endnotes)

- 1 Ч.Пирсийн семиотикийн уламжлалаар замнахдаа Ч.В.Моррис синтаксис, семантик, прагматик талбарыг хооронд нь ялгасан байдаг. Morris Ch.W., *Foundation of the Theory of Signs//International Encyclopedia of Unified Science/* O. Neurath, R. Carnap & Ch. Morris (ed.). Vol. I, pt. 2 (1938): 77-137-г үз. Нэр томъёоны хэрэглээний тухайд бид гол нь дараах бүтээлүүдэд тулгуурлана: Wittgenstein L. *Philosophical Investigations*, 1945; Austin J.L. *How to Do Things with Words*. Oxford, 1962; Searl J.R. *Speech Acts*. Cambridge U.P., 1969; Habermas J., *Unbereitende Bemerkungen zu einer Theorie der Kommunikativen Kompetenz//Habermas & Luhmann, Theorie der Gesellschaft oder Sozialtechnologie* (Stuttgart: Suhrkamp, 1971); Ducrot O. *Dire et ne pas dire* (Paris:Hermann, 1972); Poulain J., *Vers une pragmatique nucleaire de la communication* (Dactilogr., Universite de Montreal, 1977). Мөн Watzlawick et al. *Pragmatics of Human Communication*-г үз.
- 2 Денотаци нь энд логикийн сонгодог хэрэглээн дэх дескрипцитэй тохирч байна. Куайн денотатыг true of (...-н үнэн) гэдгээр солидог. W.V.Quine. *Le mot et la chose*. Flammarion, 1977. p.140, n. 2-г үз. А.Остин “дескриптив”, “констатив” зэрэг нэр томъёог илүүд үздэг: Op.cit. p.39.
- 3 Хэлний онолд Остиноос эхлэн “перформатив” нь чанд утгатай болсон (Op.cit., p.39 et passim). оролт/гаралт харилцааны хэмжигдэхүйц үр өгөөжийн тогтсон утга болсон (жишээлбэл системийн) перформанс (performance), перформатив (performativite) шинж гэсэн нэр томъёотой цаашдаа бид тааралдана. Энэ хоёр утга бие биедээ бүрэн харшилдаггүй. Остины хувьд перформатив нь перформансын оптимум болдог.
- 4 Эдгээр категорийг саяхан Хабермас “Unbereitende Bemerkungen ...”-даа задлан шинжилж, Ж.Пулен өмнө эш татсан өгүүлэлд авч үзжээ.
- 5 Wittgenstein L. *Investigations philosophiques*, Op.cit., §23.
- 6 Neumann J., von, Morgenstern O. *Theory of Games and Economic Behavior*. Princeton

- U.P., 1948, 3e ed., 1954. p.49: “Тоглоом бол өөрийг нь тодорхойлж буй дүрмүүдийн цогц юм”. Витгенштейнийхээр тоглоом гэдэг ойлголт нэг тодорхойлолтоор илэрхийлэгдэхгүй, учир нь уг тодорхойлолт өөрөө хэлний өвөрмөц тоглоом байдаг (Op.cit., §65-84).
- 7 Энэ нэр томъёог Сийрл гаргасан: “Ярих үйл нь яриан харилцааны анхдагч [хамгийн бага] суурь нэгж” (Op.cit. p.52). Бид үүнийг харилцаа гэхээсээ *agon* (тэмцэлдээн)-д илүүтэй хамааруулж байна.
 - 8 Эмгэнэлт жүжгийн анхны зохиогчдыг эс дурдвал зөрчил тэмцэл нь Хераклитын онтологи, софистуудын диалектикийн үндэс болдог. Аристотель “Топик”, “Софист няцаалтын тухай” зэрэгтээ диалектикийн талаарх ихэнх эрэгцүүллийг нь няцаасан. Ф.Ницшегийн “Бичигдээгүй таван номны таван өмнөх үг” (1872) бүтээлийн “Хомерийн хувьд тэмцэлдээн”; ”Насан эцэслэсэний дараах тэмдэглэл 1870-1873”-г бас үз.
 - 9 Л.Ельмслевийн тогтоосон утгаар: Hjelmslev L. *Prolegomena to a Theory of Language*. Whitfield, Madison, U.Wisconsin Press, 1963; Р.Барт “Семиологийн үндсүүд” (Barthes R. *Elements de semiologie* (1964). Paris: Seuil, 1966. §IV. 1.)-дээ үүнийг задлан шинжилсэн.